



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД  
АУДИТЫН АЛБА  
ТАНИЛЦУУЛГА**

321 дугаар байр, Лувсанданзанжанцангийн өргөн  
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70444469

Цахим шуудан: Sankhuuaudit.bkh.gov.mn  
Цахим хаяг: www.sankhuu.bkh.gov.mn

2023-09-15 № 8/42

Засаг даргын тамгын газрын 2021,  
2022 оны төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт,  
зарцуулалтад хяналт шалгалт  
хийсэн тухай

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.2 дахь “Аймаг, нийслэлийн Засаг даргын тусгай бүрэн эрх”, 8.2.3 дахь “сум, дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна”, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна”, Сангийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрмийг тус тус үндэслэн хяналт шалгалтыг явууллаа.

**Хоёр. Шалгалтын зорилго.**

Хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталж гаргасан дүрэм, журам, стандарт, норм нормативын хэрэгжилтэд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн байдал, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, үр өгөөжийг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэх, ажил хариуцсан албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлэх, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ.

**Гурав. Хяналт шалгалтын хийх үндэслэл, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хамрах хүрээ, хугацаа.**

642308028



1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр баталсан 07/19 тоот удирдамжийн дагуу Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд 2021, 2022 оны дансны дэлгэрэнгүй хуулга, санхүүгийн болон бусад тайлан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалт, удирдлагын гаргасан шийдвэр, мэдээ судалгаа болон бусад баримтууд (дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт гэх мэт) хамрагдсан.

2. Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021, 2022 оны санхүү, төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, гүйцэтгэлт хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Бат-Эрдэнэ 2023 оны 09 дүгээр сарын 08-наас 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэлээ.

3. Тус байгууллага нь Төрийн сангийн Орон нутгийн харилцах 100030955001 тоот харилцах данс, нэмэлт санхүүжилтийн 100030955402 тоот дансаар орлого зарлагын гүйлгээ хийж, төсөв хөрөнгийг захиран зарцуулсан, шалгалтад хамрагдсан тайлант хугацааны санхүүгийн баримтад гарын үсгийн нэгдүгээрийг дарга Р.Гантулга, (2021.01.01-ээс 2022.12.31 хүртэл), гарын үсгийн хоёрдугаарыг Нягтлан бодогч Б.Дэлгэрдалай (2021.01.01-ээс 2022.12.31-ийг хүртэл) нар зурж төсвийг захиран зарцуулж, эд хариуцагчаар П.Цэцэгдэмбэрэл ажилласан байна.

#### **Дөрөв. Байгууллагын талаарх ерөнхий мэдээлэл:**

1. Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь Цэнгэл 1-р баг, Давааны ам 2-р баг, Буга 3-р баг, Хөвийн ам 4-р баг Пионер толгой 5-р багийн нийт 2345 хүн амд хууль тогтоомжийн хэрэгжилт, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, хууль ёсыг чандлан сахиулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай хүргэх зорилгоор Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын орлогч, Санхүүгийн албаны дарга, Хөдөө аж ахуйн тасгийн дарга, Багийн дарга Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Төсөв төрийн сангийн мэргэжилтэн, Хууль эрх зүйн дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, нягтлан бодогч, нярав, биеийн тамир арга зүйн, архив бичиг хэргийн ажилтан, жолооч, үйлчилгэгч, ачигч, нийт 24 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

**Тав. Өмнөх хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт.**



Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны хяналт шалгалтаар дараах зөрчил илэрсэн байна.

1. Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулалтад хяналт сул Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүйгээр хөрөнгө зарцуулсан, Засаг дарга өөрөө өөртөө давуу байдлыг бий болгосон.

2. Нягтлан бодогч тооцооллын алдааг санамсаргүй гарган 2020 онд авлагатай үүсгэж ажилласан.

3. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийх комиссын гишүүд хөрөнгө дутагдсан атал байгаа мэтээр тооллого хийсэн хөрөнгийн ашиглалтыг тодорхойлоогүй чанаргүй гүйцэтгэж үр дүнг тооцоож баталгаажуулаагүй.

4. Аймгийн аюулгүй нөөцөөс 1888 боодол өвс 22,656,000 төгрөгийн бараа материалын тайлан гаргаагүй 2020 оны санхүүгийн тайлан нь дарга, нягтлан бодогч нар нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжүүлж ажиллаагүй.

5. Албан томилот, тээвэр шатахууныг анхан шатны баримтыг бүрдэл дутуу байхад гүйлгээ хийж зарцуулсан.

6. Тээвэр шатахууны тооцоог тухай бүр хийгээгүй, замын хуудсыг хөтлөхдөө автомашины спидометрийн заалтыг бичээгүй Автотээврийн хэрэгслийн хувийн хэрэгт ажлын гүйцэтгэл, зарцуулсан шатахуун, тосолгооны материал, оношлогоо, үйлчилгээ хийсэн тэмдэглэл, ашиглалтын засвар хийсэн тэмдэглэл, шинээр тавьсан үндсэн эд анги, сэлбэгийн бүртгэл, техникийн хяналтын улсын үзлэгт орсон тэмдэглэл, дугуйн ашиглалт, хувийн хэргийг хөтөлсөн албан тушаалтны тэмдэглэлийг хөтлөөгүй.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 оны Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 147,004,000 төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс 352,000 төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 139,307,100 төгрөгийн 2 албан шаардлага, 7,345,300 төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлсэн, 2022 оны Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,393,410 төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс 2,496,410 төгрөгийн зөрчилд 4 төрлийн акт тогтоож, 13,897,000 төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

**Зургаа. Хяналт шалгалтад хамрагдсан асуудлууд, илэрсэн зөрчил, дутагдлын талаар.**

**6.1. Байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт, түүний биелэлт, санхүүгийн үйл ажиллагааны үр дүн**

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь мөнгөн гүйлгээний тайлангаар 2021 онд Орон нутгийн төсвөөс 430,136,100 төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 367,500 төгрөг нийт 430,503,600 төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 421,602,795



төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж орон нутгийн төсөвт 8,900,805 төгрөгийг төвлөрүүлж, 2022 онд Орон нутгийн төсвөөс 560,281,000 төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 343,700 төгрөг, нийт 560,624,700 төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 477,000,450 төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж орон нутгийн төсөвт 83,624,250 төгрөгийг төвлөрүүлж ажилласан байна.

## Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## Хүснэгт-1

(төгрөг)

№	Үзүүлэлт	2021 он		2022 он		Өөрчлөлт (ТГ)	
		Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	гүйцэтгэл дүнгээр	Хувь
1	2	3	4	5	6	7	8
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	229,743,000	229,246,671	252,508,800	251,668,985	22,765,800	9.05
2	Ажил олгогчоо НДТШ	31,311,300	31,311,300	32,233,600	32,189,992	922,300	2.87
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,784,700	19,179,148	56,756,900	33,462,230	36,972,200	110.49
4	Хангамж, бараа материалын зардал	32,408,100	32,272,167	36,280,500	36,090,822	3,872,400	10.73
5	Эд хогшил	12,909,400	9,114,500	7,000,000	2,813,800	(5,909,400)	(210.01)
6	Томилолт	6,831,000	6,385,000	9,015,600	6,181,000	2,184,600	35.34
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	9,276,500	8,767,791	4,226,500	3,889,529	(1,873,500)	(48.17)
8	Бараа үйлчилгээний бусад зардал	87,739,600	84,193,717	129,178,700	83,566,606	41,439,100	49.59
9	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	1,500,000	1,500,000	34,424,100	27,481,186	32,924,100	119.81
10	Төлвөрүүлэх зардал		8,900,805	-	83,624,250	-	-
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>		<b>428,327,100</b>	<b>418,810,794</b>	<b>561,624,700</b>	<b>477,344,150</b>	<b>133,297,600</b>	<b>27.92</b>
1	туслах үйл ажиллагааны орлого	<b>1,000,000</b>	<b>367,500</b>	1,000,000	343,700	(23,800)	(6.92)
2	Орон нутгийн төсвөөс санхүүжих	430,503,600	421,602,795	560,624,700	477,000,450	55,397,656	11.61
<b>Санхүүжүүлэх эх үүсвэр</b>		<b>430,503,600</b>	<b>421,602,795</b>	<b>561,624,700</b>	<b>477,344,150</b>	<b>55,397,656</b>	<b>11.61</b>

Тус байгууллагын 2022 оны орон нутгийн санхүүжилт 130,121,100 төгрөг 27.26 хувиар, гүйцэтгэл 55,373,857 төгрөг 11.6 хувиар тус тус өссөн нь албан хаагчдын цалин, биеийн тамир арга зүйн орон тоог нэмэгдсэнтэй холбоотой байна.

Цалин хөлсний олголт.

Сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд албан хаагч нарт нийт 229,246,670 төгрөгийн цалинг олгохоор тооцоолж нийгмийн даатгалын шимтгэлт, хувь хүний орлогын албан татварын суутгалд, Үйлдвэрчний эвлэлийн суутгал, бусад суутгалд нийт 63,199,441 төгрөгийн суутган 166,047,229 төгрөгийг олгосон, 2022 онд 251,668,984 төгрөгийн цалин бодогдож, суутгалд 74,327,494 төгрөгийн шимтгэл, татвар, бусад суутгалыг суутгаж багш, ажилчдад 177,341,490 төгрөгийн цалин хөлсийн албан хаагч нарт олгосон байна.

## Цалин хөлс

## Хүснэгт-2

(төгрөг)

№	Ангилал	2021		2022	
		Нийт дүн	Хувь	Нийт дүн	Хувь
1	2	3	6.0	5	6.0
1	Бодогдсон үндсэн цалин	161,542,184	70.5	164,208,393	65.2
3	Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл	5,422,229	2.4	11,366,957	4.5
4	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл	7,918,833	3.5	9,295,959	3.7
1	2	3	4	5	6
5	Зэргийн нэмэгдэл	4,706,354	2.1	6,024,873	2.4



7	Ур чадвар	3,581,596	1.6	5,096,369	2.0
8	Үр дүнгийн урамшуулал	7,113,825	3.1	15,553,921	6.2
9	Ээлжийн амралт	17,821,865	7.8	18,842,406	7.5
10	Онцгой нөхцлийн нэмэгдэл	18,808,126	8.2	19,119,046	7.6
11	Нууцын нэмэгдэл	1,075,004	0.5	1,080,530	0.4
12	ЭБАТ-ын нэмэгдэл	1,075,004	0.5	1,080,530	0.4
13	Цалингийн зөрүү	181,650	0	0	0
14	Нийт дүн	229,246,670	100	251,668,984	100
15	нийт суутгал	63,199,441	28	74,327,494	30
16	Нийт гарт олгох дүн	166,047,229	72	177,341,490	70

2022 оны цалингийн хөлсний гүйцэтгэлийг өмнөх оныхтой харьцуулахад 22,422,314 төгрөг буюу 8.9 хувиар өссөн нь хүүхэд харах чөлөөтэй байгаа албан хаагчдын ажлын хавсран гүйцэтгэсний нэмэгдэл, албан хаагчдын үр дүнгийн урамшуулал өссөнтэй холбоотой байна.

### **Нийгмийн даатгалын шимтгэл**

Нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалтын тайлангаар 2021, 2022 онууд нийт 491,040,795 төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого мэдээлснээс ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 62,509,255 төгрөг, даатгуулагчаас 57,453,980 төгрөг, нийт 119,963,268 төгрөг, мөнгөн гүйлгээгээр 119,963,268 төгрөгийг Нийгмийн даатгалын харилцах дансруу шилжүүлж, шимтгэлийн авлага, өр төлбөргүй ажилласан байна.

### **Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт**

#### **Хүснэгт-3**

(төгрөг)

№	хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого	2021 ногдуулсан шимтгэл /төгрөг/			жирэмсэн амаржсан хүний тоо	хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого	2022 онд ногдуулсан шимтгэл /төгрөг/			
		нийт дүн	Үүнээс:				нийт дүн	Үүнээс:		
			Ажил олгогч	Даатгуулагч				Ажил олгогч	Даатгуулагч	
1	18,462,497	4,800,249	2,492,437	2,307,812	-	-	19,117,825.00	4,588,278.11	2,389,728.18	2,198,549.93
2	18,875,245	4,907,564	2,548,158	2,359,406	-	-	19,117,825.00	4,588,278.11	2,389,728.18	2,198,549.93
3	18,875,245	4,907,564	2,548,158	2,359,406	-	-	19,337,780.00	4,641,067.32	2,417,222.56	2,223,844.76
4	18,901,918	4,914,499	2,551,759	2,362,740	-	-	19,142,578.00	4,594,218.84	2,392,822.31	2,201,396.53
5	18,901,918	4,914,499	2,551,759	2,362,740	-	-	19,263,629.0	4,623,271.11	2,407,953.70	2,215,317.41
6	18,901,918	4,914,499	2,551,759	2,362,740	-	-	20,912,470.00	5,018,992.90	2,614,058.80	2,404,934.10
7	18,019,699	4,324,728	2,252,462	2,072,265	-	-	19,907,554.00	4,777,813.08	2,488,444.31	2,289,368.77
8	19,740,337	4,737,681	2,467,542	2,270,139	-	-	22,075,511.00	5,298,122.79	2,759,438.95	2,538,683.84
9	18,618,844	4,468,523	2,327,356	2,141,167	-	-	27,607,556.00	6,625,813.54	3,450,911.55	3,174,868.99
10	18,426,252	4,374,001	2,303,282	2,070,719	1	420,000	20,794,318.00	4,990,636.44	2,599,289.81	2,391,346.63
11	18,962,724	4,502,754	2,370,341	2,132,413	1	420,000	22,695,017.00	5,446,804.21	2,836,877.19	2,609,927.02
12	25,552,524	6,084,306	3,194,066	2,890,240	-	-	28,829,611.00	6,919,106.75	3,603,701.43	3,315,405.32
13	232,239,121	57,850,865	30,159,078	27,691,787	840,000	258,000	258,801,674.00	62,112,403.20	32,350,176.97	29,762,193.23

### **6.2. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт тооцоо бодолт.**

Байгууллагын өмч хөрөнгийг ашиглаж байгаа албан хаагч бүрээр картжуулж, эзэмшүүлсэн байна. Хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр даргын тушаалаар ажлын хэсэг томилогдон тооллого хийж илтгэх хуудсаар дүнг гарган нягтлан бодогч тооцоог бодож баталгаажуулсан байна.

Засаг даргын Тамгын газар нь 2021 онд төсвийн хөрөнгөөр 14,426,200 төгрөгийн хөрөнгө худалдан авч, бусад эх үүсвэрээр 60,230,912 төгрөгийн хөрөнгө орлого авч, 20,000,000 төгрөгийн дуусаагүй барилгыг шилжүүлж, 2022 онд төсвийн хөрөнгөөр 17,532,900 төгрөгийн хөрөнгө бэлтгэн, бусад эх үүсвэрээр 1,498,093,455 төгрөгийн хөрөнгийг орлогод авч, 2022 оны санхүүгийн тайлангаар 3,410,791,082 төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.



## Үндсэн хөрөнгө

Хүснэгт-4

(төгрөг)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн			Акталсан хөрөнгө	Шилжүүлсэн	Эцсийн үлдэгдэл
			Төсвийн хөрөнгө	Бусад эх үүсвэр	шилжүүлэн авсан			
Үндсэн хөрөнгийн тайлан 2021								
1	Барилга байгууламж	1,147,255,162	-	-	-	-	-	1,147,255,162
2	Авто тээврийн хэрэгсэл	222,134,800	-	-	-	37,660,000	-	184,474,800
3	Машин тоног төхөөрөмж	167,266,997	10,988,800	13,085,620	-	-	-	191,341,417
4	Тавилга эд хогшил	90,402,655	903,400	3,110,000	-	-	-	94,416,055
5	Дуусаагүй барилга	20,000,000	-	-	-	-	20,000,000	-
6	Номын фонд	595,500	534,000	-	-	-	-	1,129,500
7	Бусад үндсэн хөрөнгө	223,656,892	-	44,035,292	20,000,000	-	-	287,692,184
8	Программ хангамж	950,000	2,000,000	-	-	-	-	2,950,000
1	2	3	4	5	6	7	8	9
9	Бусад биет бус хөрөнгө	11,926,000	-	-	-	-	-	11,926,000
<b>Дүн</b>		<b>1,884,188,006</b>	<b>14,426,200</b>	<b>60,230,912</b>	<b>20,000,000</b>	<b>37,660,000</b>		<b>1,921,185,118.3</b>
Үндсэн хөрөнгийн тайлан 2022								
1	Барилга байгууламж	1,147,255,162	-	1,212,465,000	-	-	-	2,359,720,162
2	Авто тээврийн хэрэгсэл	184,474,800	-	40,353,000	-	-	-	224,827,800
3	Машин тоног төхөөрөмж	191,341,417	13,902,900	74,256,100	-	15,004,900	-	264,495,517
4	Тавилга эд хогшил	94,416,055	-	14,085,000	-	11,015,491	-	97,485,564
5	Дуусаагүй барилга	-	-	-	-	-	-	0
6	Номын фонд	1,129,500	-	-	-	-	-	1,129,500
7	Бусад үндсэн хөрөнгө	287,692,184	3,630,000	140,760,355	-	-	-	432,082,539
8	Программ хангамж	2,950,000	-	-	-	-	-	2,950,000
9	Бусад биет бус хөрөнгө	11,926,000	-	16,174,000	-	-	-	28,100,000
<b>Дүн</b>		<b>1,921,185,118</b>	<b>17,532,900</b>	<b>1,498,093,455</b>	<b>-</b>	<b>26,020,391</b>	<b>-</b>	<b>3,410,791,082</b>

Тус байгууллага нь 2021 онд төсвийн хөрөнгөөр 18 нэр төрлийн 22 ширхэг нийт 14,426,200 төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж 14 нэр төрлийн 26 ширхэг нийт 41,758,859 төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, Аймгийн Засаг даргын Тамгын газраас 7 нэр төрлийн 4,272,620 төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын гудамжны гэрэлтүүлэгийн сайжруулалт 9,436,433 төгрөг, дуусаагүй барилгын дансанд бүртгэлтэй 20,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй хүүхдийн паркийн тохижилтийг, бусад үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн авсан байна. Авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 18,660,000 төгрөгийн үнэтэй УАЗ-469, 19,000,000 төгрөгийн үнэтэй усны машиныг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 1а/470 дугаар албан бичгийн дагуу Гурванбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн 20 дугаар тогтоолын дагуу дуудлага худалдааг зохион байгуулж данснаас хассан байна.



2022 онд төсвийн хөрөнгөөр 17,532,900 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 34,773,000 төгрөгийн үнэтэй усны машин, сумын Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй 16,174,000 төгрөгийн газар, Жи энд юу гоулд ХХК-наас 1,200,000,000 төгрөгийн өртөгтэй спорт заал, бүдүма ХХК-наас 2,790,000 төгрөгийн үнэтэй 2 ширхэг мотоцикль нийт 5,580,000 төгрөг, Цэнгэл 1-р баг, Давааням 2-р багийн төвийн барилга сайжруулалтад 12,465,000 төгрөгийн завсар, аж ахуйн нэгж байгууллагуудаас 229,101,455 төгрөгийн худаг, тоног төхөөрөмжийг үнэт төлбөргүй орлогоор санхүүгийн тайлан бүртгэж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 9/29 дүгээр тогтоолын дагуу 26,020,391 төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

### Бараа материал

#### Хүснэгт-5

(төгрөг)

№	Үзүүлэлт	2021 он					
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Хасагдсан		Эцсийн үлдэгдэл
			Төсвийн хөрөнгөөр	Хандив	Зарцуулсан	бусад	
1	2	3	4	5	6	7	8
1	Тусгай зориулалтын материал	11,720,800	4,565,000	51,000,000	53,398,000		13,887,800
2	Эм боох материал	0	10,395,000	500,000	10,430,000		465,000
3	Бичиг хэргийн материал	2,601,600	5,056,820		5,081,820	530,000	2,046,600
4	Аж ахуйн материал	14,977,814	6,020,700	4,809,900	6,413,700	4,754,800	14,639,914
5	Барилгын засвар	0	-	5,424,000	5,424,000		-
6	Хүнсний материал	0	5,996,280	20,000	5,614,280	-	402,000
7	Бусад хангамж		37,168,625	57,988,400	82,134,525	-	13,022,500
8	Сэлбэг хэрэгсэл		5,023,500		5,023,500		-
9	Түлш шатах тослох материал		41,237,893	1,995,450	42,392,003		841,340
<b>Нийт дүн</b>		<b>29,300,214</b>	<b>115,463,818</b>	<b>121,737,750</b>	<b>215,911,828</b>	<b>5,284,800</b>	<b>45,305,154</b>
<b>2022 он</b>							
1	Тусгай зориулалтын материал	13,887,800	8,637,000	3,817,600	6,868,500	2,670,000	16,803,900
2	Эм боох материал	465,000	92,000	6,541,000	3,095,000		4,003,000
3	Бичиг хэргийн материал	2,046,600	7,744,350		7,674,400	264,100	1,852,450
4	Аж ахуйн материал	14,639,914	6,097,400	3,607,500	5,373,300	2,185,300	16,786,214
5	Барилгын засвар	-	838,500		838,500		-
6	Хүнсний материал	402,000	2,298,850		2,700,850		-
7	Бусад хангамж	13,022,500	19,951,750	14,745,000			47,719,250
8	Сэлбэг хэрэгсэл	-	2,997,300		2,997,300		-
9	Түлш шатах тослох материал	841,340	45,143,646	271,000	46,255,986		-
<b>Нийт дүн</b>		<b>45,305,157</b>	<b>93,800,800</b>	<b>28,982,100</b>	<b>75,803,842</b>	<b>5,119,407</b>	<b>87,164,822</b>

Бараа материалын 2021 оны тайлангаар 29,300,214 төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэйгээс тайлант онд 115,463,818 төгрөгийн материал худалдан авч, 121,737,750 төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авч 215,911,828 төгрөгийн материалын зарцуулж, 5,284,800 төгрөгийн материалыг данснаас хасаж 45,305,154 төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, 2022 онд төсвийн хөрөнгөөр 93,800,800 төгрөгийн материалыг худалдан авч, 28,982,105 төгрөгийн материалын үнэ төлбөргүй хүлээн авч, 75,803,842 төгрөгийн материалын зарцуулж, 5,119,407 төгрөгийн материалыг данснаас хасаж, 2022 оны санхүүгийн тайлангаар 87,164,822 төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

2021 онд аж ахуйн материалын дансанд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4,117,000 төгрөг, Аймгийн Засаг даргын Тамгын газраас 532,900 төгрөгийн



үнэтэй дотоод сүлжээний дагалдах хэрэгсэл, Аймгийн Сонгуулийн хорооны 40,000 төгрөгийн үнэтэй Төрийн далбаа, Давааням 2-р баг, Буга 3-р багийн төвүүдэд хийсэн засварын материал 5,424,000 төгрөг, Өвс тэжээлийн орлого 57,988,400 төгрөг, Бактержуулсан будаа 50,000,000 төгрөг, маск 1,000,000 төгрөг, Тээвэр шатахууны хандивт 1,995,450 төгрөг, хүнсний материал 20,000 төгрөг, Эм боох материалд 500,000 төгрөг, нийт 121,737,750 төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр орлогод авч зарцуулан, сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 06-ны 44 дүгээр тушаалаар бараа материалын данснаас 14 нэр төрлийн 5,284,800 төгрөгийн материалыг актлаж устгасан байна.

2022 онд Аж ахуйн материалын дансанд 118 ширхэг 3,607,500 төгрөг, Малын тэжээлийн дансанд 983 ширхэг 14,745,000 төгрөгийн ногоон тэжээл, тусгай зориулалтын материалын дансанд 89 ширхэг 3,817,600 төгрөг, түлш, шатах тослох материалын дансанд 271,000 төгрөгийн шатахуун, Эм боох материалын дансанд 6,451,003 төгрөгийн эм хэрэгслийг үнэ төлбөргүйгээр орлого авч зарцуулсан байна. Сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 51 дүгээр тушаалаар эргэлтийн хөрөнгөнөөс 20 нэр төрлийн 5,148,018 төгрөгийн бараа материалын данснаас хассан байна.

**6.3. Өр авлагын байдал, өссөн бүүрсан шалтгааныг тодруулж барагдуулалт, найдваргүй авлага, эзэнгүй өглөгийн талаар:**

Тус байгууллага нь 2021 онд эхний үлдэгдлээр 300,000 төгрөгийн ажиллагчидтай холбоотой авлагатайгаас тайлант оны эцэст 282,500 төгрөгийн өглөг, 17,117,831 төгрөгийн авлага үүсгэж ажилласан, 2022 онд 282,500 төгрөгийн өглөг, 32,982 төгрөгийн авлагыг барагдуулж байгууллагаас авах авлагад 1,040,730 төгрөгийн авлага нэмэгдэж 2022 оны санхүүгийн тайлангаар 18,125,579 төгрөгийн авлага үүсгэж ажилласан.

**Өглөг авлагын дэлэрэнгүй**

Хүснэгт-6

(төгрөг)

№	Төрөл	2021 онд үүссэн өглөг, авлага				
		Эхний үлдэгдэл		Нэмэгдсэн	Хорогдсон	Үлдэгдэл
		Өглөг	Авлага			
1	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	0	310,596,152	310,596,152	0
2	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	0	23,599,249	23,599,249	0
3	Бусад өглөг	-	-	183,552,909	183,270,409	282,500
	<b>Өглөгийн дүн</b>	-	<b>0</b>	<b>517,748,310</b>	<b>517,465,810</b>	<b>282,500</b>
1	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	300,000	32,982	300,000	32,982
2	Байгууллагаас авах авлага	-	-	17,084,849	-	17,084,849
	<b>Авлагын дүн</b>	-	<b>300,000</b>	<b>17,117,831</b>	<b>300,000</b>	<b>17,117,831</b>
		2022 онд				
1	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	-	340,947,975	340,947,975	0
2	Бараа үйлчилгээний зардлын өглөг	282,500	-	519071777.2	519,354,277	0
	<b>Өглөгийн дүн</b>	<b>282,500</b>	<b>0</b>	<b>860,019,752</b>	<b>860,302,252</b>	<b>0</b>
1	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	32,982	129,965	162,947	0
2	Байгууллагаас авах авлага	-	17,084,849	18,125,579	17,084,849	18,125,579
	<b>Авлагын дүн</b>	-	<b>17,117,831</b>	<b>18,255,544</b>	<b>17,247,796</b>	<b>18,125,579</b>

Байгууллагаас авах 18,125,579 төгрөгийн авлага нь нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэлийг орон нутгийн төвлөрүүлэх дансанд төвлөрүүлж санхүүгийн тайланд жил бүр авлагаар тусгасан байна.



**6.4. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт.**

1. Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тооцоолох, цалингийн "ТАЦНС" программ, ашигладаг бөгөөд 2021, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн бодиттой байдалд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас аудит хийж гүйцэтгэсэн байна.

2. Санхүү аж ахуйн үйл ажиллагаа, байгууллагын хөрөнгө мөнгөнд бүртгэлээр тавих хяналт хэвийн явагдсан, НББ-ийн "Acolous", цалингийн нэдсэн систем "ТАЦНС" программаар бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийг гаргасан, Санхүү төрийн сангийн хэлтэст төсвийн гүйцэтгэлийн тайлан, сар бүрийн мэдээг хугацаанд нь гаргасан, 2021, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хэлбэрээр байршуулсан, НДШ-ийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг сар, улирал тутамд цахимаар илгээж, цаасаар баталгаажуулсан байна.

**6.5. Төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт зарцуулалт, үр дүн, Засгийн газрын зээл, тусламж, эргэн төлөгдөх нөхцлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, үр дүн.**

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 2021, 2022 онуудад Сумын ЗДТГ-аас 21,375,429 төгрөгийн тээврийн хөлс шүлхийн шатахуун, өмнөх оны үлдэгдэл, иргэн Хүрэлхуягаас 5,000 төгрөгийн нохойны татвар, Чандмань БХР байгууллагаас усны үнийн хөнгөлөлт 11,923,800 төгрөг, Статистикийн хэлтсээс тооллогын зардал 2,250,217 төгрөг, Иргэнээс Ковидын хандив 600,000 төгрөг, Өвс тэжээлийн орлого 5,318,950 төгрөг, ГБХЗХГазраас хамтарсан багийн зардал 1,800,000 төгрөг, Цахим тендерийн үнэ 910,000 төгрөг, Аймгийн ХХААГ-аас оготоно устгал мал ангилалтын зардал 9,272,000 төгрөг, Сумын Эрүүл мэндийн төвөөс оношлуурын үнэ 3,520,000 төгрөг, ЭМТ-ын хуучин барилгын газар чөлөөлсөн орлого 6,400,000 төгрөг, Сангийн Сайдын багцаас 5,000,000 төгрөг, Иргэн Г.Ууганбаяраас тэмцээний зардал 4,000,000 төгрөг нийт 72,375,396 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт санхүүжилтийн данс**

Хүснэгт-8		(төгрөг)		
№	Санхүүжилт олгосон байгууллага	Зориулалт	2021 он	2022 он
1	2	3	4	5
Санхүүжилт				
1	Иргэн	Татвар	5,000	-
2	СЗДТГ	Захирамжаар ачаа тээврийн хөлс	3,332,080	-
3	Чандмань БХР	Усны үнийн чөлөөлөлт	9,772,200	2,151,600
4	Статистикийн хэлтэс	Мал тооллогын зардал, ХААТ-ын зардал	860,017	1,190,200
5	Иргэн	Ковидын хандив	600,000	-



1	2	3	4	5
6	Цэцэгдэмбэрэл	Өвсны үнэ	5,318,950	-
7	ГБХЗХГазар	Хамтарсан багийн зардал	1,800,000	-
8	Тендерийн хороо	Цахим тендерийн үнэ	175,000	735,000
10	ЭМТ	Оношлуурын үнэ	3,520,000	-
11	Аймгийн ХХААГ	Оготоно устгал, Мал ангилалтын зардал	9,072,000	200,000
12	Иргэн	Газар чөлөөлөлтийн орлого	6,400,000	-
13	СЗДТГ	Урьд оны үлдэгдэл	-	17,084,849
14	СЗДТГ	Шүлхийн шатахуун	-	958,500
15	Сангийн яам	Сангийн Сайдын багцаас санхүүжилт шилжүүлэв	-	5,000,000
16	Статистикийн хэлтэс	ХАБХХөдөлгөөнийг тандах туршилтын судалгааны зардал	-	200,000
17	Иргэн	Тэмцээний зардал	-	4,000,000
Нийт дүн			48,855,247	31,520,149

### Гамшгаас хамгаалах, сэргийлэх, сургалт сурталчилгааны зардал

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны Төсөв батлах тухай 06/02 дугаар тогтоолоор Засаг даргын Тамгын Газрын Гамшгаас хамгаалах, сэргийлэх, сургалт сурталчилгааны зардал 15,350,000 төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 15,334,873 төгрөгийг зарцуулж, 15,127 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

### Гамшгаас хамгаалах зардлын зарцуулалт

Хүснэгт-8

(төгрөг)

№	Харилцагчийн нэр	Мөнгөн дүн	Гүйлгээний утга
1	НИК ХХК	747,850.00	Шатахуун /Шүлхий/
2	НИК ХХК	89,425.00	Шатахуун /Шүлхий/
3	Баясах гоо ихэр ХХК	300,000.00	Хамгаалах хэрэгсэл
4	НИК ХХК	161,200.00	Шатахуун /Шүлхий/
5	НИК ХХК	1,545,050.00	Шатахуун /Шүлхий/
6	Наян булаг ганга ХХК	65,000.00	Автомат /шүлхий/
7	С.Цэнд-Аюуш	360,000.00	Томилолт
8	Б.Батэрдэнэ	360,000.00	Томилолт
9	Сум дундын ойн анги	282,500.00	Өвс тэжээлийн өр
10	Түйн голын төгөл ХХК	1,980,000.00	Модны үнэ Гурванбулаг
11	НИК ХХК	448,598.00	Бэлчээр ариутгалын шатахуун
12	Эвт уран санаа ХХК	1,920,000.00	Гарын авлага
13	Сум шиг Ирээдүй ХХК	2,500,000.00	Газрын генераторын түлшний үнэ
14	Өлзийтийн хүүхдүүд ХХК	3,981,250.00	Хивэгний үнэ
15	Б.Мөнхжаргал	534,600.00	Хөөсний үнэ
16	Б.Мөнхжаргал	59,400.00	3221000854892 9008489
17	Бх.Гу ОНЕРөнхий орлого	15,127.00	Төвлөрүүлэлт
нийт дүн		15,350,000.00	

### Ан агнуурыг орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

1. Гурванбулаг сумын агнуурын нөөцийн орлого 2021 онд 109,209,600 төгрөг, 2022 онд 315,388,800 төгрөгийн шонхорын орлого орж, үүнээс Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны Төсөв батлах тухай 06/02 дугаар тогтоолоор сумын Засаг даргын Тамгын Газрын Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал 45,950,000 төгрөг, Хур хог хаягдал, орчны бохирдолыг арилгах устгах зардал 8,654,800 төгрөг, нийт 54,604,800 төгрөгийн байгаль хамгаалах зардал зарцуулахаар баталсан байна.



2. Засаг даргын Тамгын газар нь Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд 45,950,000 төгрөгийг зарцуулахаар баталж, 10,171,533 төгрөгийг зарцуулж, 35,778,467 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

Байгаль орчныг хамгаалах зардлын зарцуулалт

Хүснэгт-10		(төгрөг)		
№	Харилцагчийн нэр	Захирамжийн дүн	Мөнгөн дүн	Гүйлгээний утга
1	Түйн голын төгөл ХХК	2,930,000	950,000	Модны үнэ Гурванбулаг
3	Робо Ийгл Анмэнэд Айр Виклз ХХК	1,474,000	1,474,000	Камер засвар
4	Энэртитэм ХХК	44,476,000	1,176,000	Дуран
5	НИК ХХК		813,000	Шатахуун /Байгаль орчин/
6	Баясах гоо ихэр ХХК		180,000	Чанга яригч
7	НИК ХХК		1,131,733	Шатахуун /Байгаль орчин/
8	НИК ХХК		216,800	Шатахуун /Байгаль орчин/
9	Өндөржаргалант хайрхан ХХК		590,000	Жамц давс /биотехник/
10	Дэлгэрэх асгат ХХК		3,640,000	Компьютер, принтер
11	Бх.Гу ОНЕрөнхий орлого	-	35,778,467	Төвлөрүүлэлт
Нийт дүн		48,880,000	45,950,000	

**6.6. Шалгагдаж байгаа байгууллагатай холбогдолтой төрийн захиргааны эрх бүхий байгууллагын тушаал, захирамж, зааврын биелэлт, байгууллагын хөдөлмөрийн хамтын гэрээ, дотоод журам болон байгууллага, хүмүүстэй байгуулсан гэрээ, хэлцэл нь санхүү, хууль, эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх.**

1. Гурванбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын 2022-2024 оны хамтын гэрээг хамт олны хурлаар хэлэлцэж, 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлж, 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр бүртгүүлэн мөрдөж эхэлсэн байна.

2. Сумын Засаг даргын газар нь жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд нийт 96 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай, Нягтлан бодогч бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, дүрмүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажилласан байна.

**6.7. Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөлт биелэлт үр дүнг үнэлж дүгнэх.**

1. Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 35 дугаар тушаалаар Дотоод хяналт шалгалтын зөвлөл томилсон ажилласан байна.

2. Тус байгууллагын дотоод хяналт шалгалтын зөвлөл нь 2022 оны 02 дугаар сарын 05-ны өдөр тухай жилд хийж гүйцэтгэх хяналт шалгалтын төлөвлөгөөг сумын Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хяналт



шалгалт хийж удирдамжийг даргаар батлуулж, хяналт шалгалтыг дүн илтгэх хуудсаар баталгаажуулж ажилласан байна.

#### **Илэрсэн зөрчил:**

Тус дотоод хяналт шалгалтын зөвлөл, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг боловсруулаагүй байгаа нь Засгийн Газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-н өдөр баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна”, гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

#### **6.8. Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт.**

Тайлант онуудад ажилласан нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан 13 төрлийн эрх, үүргээс 3 төрлийг үүргийг хангалтгүй биелүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, ажлыг зохион байгуулах”, гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

#### **6.9. Шилэн дансны хэрэгжилт:**

Тус байгууллага нь 2021, 2022 онуудад нийт 342 мэдээллийг байршуулахаас хугацаандаа 333 мэдээлэл, хугацаа хоцорсон 9 мэдээллийг шилэн дансанд байршуулсан байна.

#### **Шилэн дансны мэдээлэл**

Хүснэгт-9							(төгрөг)	
№	Он	Байгууллага	Хугацаандаа	Хугацаа хоцорсон	Байршуулаагүй	Нийт	Хувь	
1	2021	ЗДТГ	169	2	-	171	98.8%	
2	2022		164	7	-	171	95.9%	
Нийт дүн			333	9	-	342	97.4%	

Дээр хүснэгтээс харахад Засаг даргын Тамгын газар нь нийт мэдээлэх мэдээллээс 97.4 хувийн мэдээллийг хугацаандаа мэдээлсэн нь сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Нягтлан бодогч нар нь ажилдаа хариуцлагатай хандаж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна.

#### **6.10. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал:**

1. Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 2021, 2022 онуудын ээлжийн амралтын хуваарийг гаргаагүй нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны



06 дугаар сарын 14-ны өдрийн 166 дугаар тушаалаар баталсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 3-т “Ажил олгогч нь ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг тэдний саналыг үндэслэн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохицуулж, календарийн жилийн эхний улиралд багтаан гаргах ба баталсан хуваарийн дагуу энэ зааврын 1 дүгээр хавсралтаар баталсан ээлжийн амралт олгох мэдэгдлийг санхүү болон ажилтанд олгоно”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар баталсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 1.2-т “Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтын саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2. Өнөөгийн Баянхонгор сонины газар 2021 оны 01 дүгээр сарын 28-ны урсгал засварын зардлаас сонины эх бэлтгэх хэвүүлэх зардал 288,800 төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29 өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын 210604 “Байгууллагын өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 50,000 төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 14,350 төгрөг, нийт 64,350 төгрөгийн сэлбэгийн зардлыг бэлэн зарцуулахдаа бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, юунд зарцуулсан нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4. Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 33 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,600,000 төгрөгийн зөөврийн компьютерийг Эрүүл мэндийн төвийн албан хэрэгцээнд ашиглуулахаар худалдан авсан ч тус хөрөнгийн орлогод аваагүй санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дүгээр зүйлийн 14 дүгээр зүйл “Нягтлан бодох бүртгэл хөтлөх”, 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.4.5-т “Бүх орлого”, 20.1.1-т “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэсэн заалтын зөрчсөн байна.



5. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдөр Цагаан уул фарм ХХК-руу 2,056,500 төгрөгийн эмийн багцийг худалдан авч айл өрхөд тарааж өгөхдөө анхан шатны баримт шаардах хуудсаар нярав зарцуулаагүй байхад нягтлан бодогч зарцуулалт хийсэн нь Сангийн сайдын 2017 оны 12-р сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6-т “Шаардах хуудас”, “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

6. Иргэн Б.Лувсанцэрэнд анхны бие даасан уран бүтээлийн тоглолтыг дэмжиж Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр 800,000 төгрөгийн тэтгэмжийг олгосон байгаа нь Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1-т “Нөөц хөрөнгийг зарцуулах тухай Засаг даргын шийдвэрийн төсөл нь дор дурдсан шаардлагыг хангасан байна”, 3.1.1-т “шийдвэрийн төсөл нь энэ журмын 2.1-д заасан зориулалттай бүрэн нийцсэн болохыг танилцуулгад тодорхой тусгасан байх”, 3.1.2-т “урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх”, 3.1.3-т “нөөц хөрөнгийг зарцуулах үндэслэл, шаардлага, үр дүнг шийдвэрийн төслийн танилцуулгад тодорхой дурдсан байх”, 4.1-т “Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна” 6.3-т “Нөөц хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### **ДОЛОО. ДҮГНЭЛТ:**

Шалгалтаар Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нийт 5,809,650 төгрөгийн зөрчил илэрч, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Тус байгууллага нь үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж 2021, 2022 онуудад батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган хэмнэлттэй зарцуулж, хэмнэлтийг төвлөрүүлсэн, хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж үр дүнг тооцож бодож баталгаажуулсан байна.

1. Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль эрхзүйн мэдлэг дутмаг, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хөтлөх явцдаа дээрх зөрчлүүдийг гаргасан.



2. Байгууллагын албан хаагч нарын ээлжийн амралтын хуваарийг тушаалаар баталгаажуулаагүй, амралтын бичгээр амралтыг эдлүүлсэн.

3. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт хяналт сул, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын дагуу зарцуулаагүй.

4. Эдийн засгийн ангиллын зөрүү нийт 288,800 төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-аар тайлант жилийн зардлуудыг зарлага болгохдоо бүлгийн зардлыг эдийн засгийн ангилал, анхан шатны баримтад тулгуурлан утга агуулгад нийцэхгүй ажил гүйлгээг хийгээгүй.

5. Анхан шатны баримтын зөрчил 64,350 төгрөгийн гүйлгээ, нярав шаардах хуудсаар зарлага гаргаагүй байхад нягтлан бодогч санхүүгийн тайланд 2,056,500 төгрөгийг зарлага болгосон.

7. Хяналт шалгалт хийсэн тухай тайланг албаны дарга болон аудитын хорооны хуралд танилцуулж, дүнг байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХҮРСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ

ТАНИЛЦСАН:  
ЗАСАГ ДАРГА  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА  
НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТ-ЭРДЭНЭ  
Б.ГАНТУЛГА  
Р.ГАНТУЛГА  
Б.ДЭЛГЭРДАЛАЙ

